



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/753

Булган сум

Сургалт эрхлэн явуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, 25.3 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан "Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хууль тогтоомжийг таниулах, үйлчлүүлэгчдийн насыг тогтоох, үйлчлүүлэгч согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйлчилгээний арга барилыг төлөвшүүлэхэд чиглэсэн "Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалт"-ын жишиг хөтөлбөрийг 1 дүгээр, сургалтад хамрагдаж тэнцсэн элсэгчдэд олгох гэрчилгээний загварыг 2 дугаар, хариуцлагатай үйлчилгээний сургалт эрхлэх хуулийн этгээдийн нэрсийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэж, эрх бүхий этгээдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үр дүнг тайлагнаж, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням), Хууль, эрхзүйн хэлтэс (Б.Одхүү) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
11 дүгээр сарын 06-ны өдрийн А/753 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

**Согтууруулах ундааны хариуцлагатай
үйлчилгээний сургалтын хөтөлбөр**

Зорилго: Согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бусдад үйлчлэх үүрэг бүхий ажилтанд (менежер, зохион байгуулагч, худалдагч, зөөгч, бармен, хамгаалагч гэх зэрэгт) Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг таниулах, үйлчлүүлэгчийн насыг тогтоох, үйлчлүүлэгч согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйлчилгээний арга барилыг төлөвшүүлэхэд оршино.

Хамрах хүрээ: Булган аймгийн 16 сум 1 тосгонд үйл ажиллагаа явуулж буй согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдах тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд.

Хамтран зохион байгуулагч байгууллага: Булган аймгийн засаг даргын Тамгын газар, бүх сумдын засаг даргын Тамгын газар

Сургалтын хөтөлбөр

Д/д	Агуулга	Хугацаа
1.	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомжийг таниулах <ul style="list-style-type: none">- согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн төрөл, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох- согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох газар, өдөр, түүгээр үйлчлэхэд хориглох зүйл, цагийн хязгаарлалт- согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах тусгай шаардлага, эзэмшигчийн хариуцлага- Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид архидан согтуурахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаар хэрхэн тусгасан, оногдуулах шийтгэл	10.25-12.00
2.	Үйлчлүүлэгчийг согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйлчилгээний арга барилын талаарх ойлголт (асуулт, хариулт, ярилцлага)	12.00 - 12.20
3.	Цайны завсарлага	12.20 -12.35
4.	Согтууруулах ундааны нийгэмд үзүүлэх нөлөөлөл <ul style="list-style-type: none">- согтууруулах ундааны нийгэмд үзүүлэх ерөнхий нөлөөлөл- согтууруулах ундааны нийгэмд үзүүлэх ерөнхий сөрөг үр дагавар	12.35 - 13.50
5.	Согтууруулах ундааны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл <ul style="list-style-type: none">- архинд донтох эмгэг- хорт хавдар, элэгний хатуурал зэрэг өвчин архины хордлого ба үхэл	

	- архи нь хүний оюун ухаан, сэтгэл зүй, зан араншинд хэрхэн нөлөөлдөг; хүний бие согтууруулах ундааг хэрхэн боловсруулдаг талаар	13.50-14.05
6.	Насанд хүрээгүй эсвэл согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үйлчлүүлэгчдэд согтууруулах ундаагаар үйлчлэхээс зайлсхийх арга барил (асуулт, хариулт, ярилцлага)	14.05-14.20
7.	Шалгалт, сертификат гардуулах	14.20-14.40

11... дүгээр сарын 06.-ны өдрийн А/7.53 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



ГЭРЧИЛГЭЭ

Дугаар №

..... ОВОГ

..... НЭР

“СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ ҮЙЛЧИЛГЭЭ”-тэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйлчилгээний арга барилыг төлөвшүүлэх чиглэлээр сургалтад хамрагдсан тул гэрчилгээ олгов.

Олгосон: 202... он сар ... өдөр

Хүчинтэй хугацаа: 202... он ... сар ... өдөр

ЗАХИРАЛ: гарын үсэг, тамга (овог, нэр)

А5 цаасан дээр доороос 2 см, 2 талаас 3 см- багтаан бичих

Фонт: Times new roman 40, 18 italic, 14

Аймгийн Засаг даргын 2023 оны
11 дүгээр сарын 06-ны өдрийн А/153 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

Хариуцлагатай үйлчилгээний сургалт эрхлэх ашгийн төлөө бус
Төрийн бус байгууллагын жагсаалт

Д/д	Төрийн бус байгууллагын нэр	Регистрийн дугаар	Захирлын нэр	Хариуцлагын хэлбэр	Утасны дугаар	Хаяг, байршил
1	2	3	4	5	6	7
1	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Булган аймаг дахь салбар	1000381	Д.Оюунгэрэл	Нийгэмд үйлчилдэг ТББ	99349282, 98113243	Булган аймгийн Булган сум, Хунтайж 303 тоот
2	Булган Тогооч хоол үйлдвэрлэгчдийн холбоо (Монголын Үндэсний Хоол Үйлдвэрлэл Үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоо ТББ-ын Булган аймаг дахь салбар)	3202518	Ч.Сарантуяа	Гишүүд болон нийгэмд үйлчилдэг ТББ	99954889	Булган аймгийн Булган сум 5-р баг, Дрийм лоунж